



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот


Даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн
оролцогчид аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. "Улиастай ван-Аудит" ХХК-д даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Компанийн өөрчлөлт, аудитуудын шилжилт хөдөлгөөний талаар тухай бүр Хороонд мэдээлж байхыг "Улиастай ван -Аудит" ХХК(П.Ганцолмон)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Х.Бум-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА-2

Д.БАЯРСАЙХАН



000169